



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, <http://www.ndaatgal.mn>

2023.06.30 № 01/1345  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулгыг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 7 хуудастай

ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Ц.ГАНЦЭЦЭГ



My doc.DAMG A-5 /23.06/ sar

**1523083038**

# ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр

## **Нэг. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго:**

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтын хүрэх түвшинтэй харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоох, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## **Хоёр. Арга зүй, ашигласан эх сурвалж:**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2023 оны эхний хагас жилийн байдлаарх хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэн хийлээ.

## **Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:**

3.1. Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2023 онд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр “Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд 5 зорилт бүхий 8 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:

- 2.5.1. “Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.” зорилтын хүрээнд 3 арга хэмжээ;
- 2.5.2. “Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;
- 2.5.4. “Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын



үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;

- 2.5.5. “Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд 2 арга хэмжээ;
- 2.5.6. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй болгоно” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харуулбал:

Зорилт, арга хэмжээний дугаар	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо			
			100	90	70	Хэрэгжилт /Хувиар/
<b>2.5. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.</b>						
2.5.1.1.	Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	1		1		90
2.5.1.2.	Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	1		1		90
2.5.1.3.	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	1		1		90
<b>2.5.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.</b>						
2.5.2.1.	Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчны хүрээнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.	1		1		90
<b>2.5.4. Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.</b>						
2.5.4.1.	Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ.	1		1		90
<b>2.5.5. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.</b>						
2.5.5.1.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	1	1			100
2.5.5.2.	Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтооно.	1	1			100
<b>2.5.6 “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй болгоно</b>						
2.5.6.1.	Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим	1		1		90

хэлбэрээр хүргэнэ.					
<b>Нийт</b>	<b>8</b>	<b>2</b>	<b>6</b>	<b>0</b>	<b>92.5</b>

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнгээр:

- Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрсэн, тодорхой үр дүн гарсан 100 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ:
- Зорилт, арга хэмжээний зорилтот түвшинд бүрэн хүрээгүй боловч өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан, үр дүн гарч эхэлж байгаа 90 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ:

### **Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2023 оны эхний хагас жилийн байдлаар 92.5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэлээ.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хавсаргав.

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗАР



**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

(2023 оны эхний хагас жилийн байдлаар)

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин (хүрээгүй бол шалтгаан, нөхцлийг тайлбарлах)	Гүйцэтгэлийн хувь
2.5.1. Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.	1.	Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	-	Нийгмийн даатгалын эрх зүйн шинэчлэл хийгдээгүй, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдээгүй байна.	Нийгмийн даатгалын эрх зүйн орчин шинэчлэгдэж олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдсэн байна.	<p>Нийгмийн даатгалын ерөнхий, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг тус тус боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөл дээр дахин ажиллаж Санхүү бүртгэлийн газар, Хяналт шалтгалын газар, Тамгын газар, Дотоод аудит, мониторингийн газар, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, Мэдээллийн технологийн төвөөс холбогдох саналыг авч тусган Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолт, хуулийн үйлчлэх хүрээ, нийгмийн даатгалын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих, сангийн хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүн, шимтгэл төлснөөр тооцох хугацаа, итгэлцүүр, шимтгэлээс чөлөөлөх, нөхөн төлүүлэх, буцаан олгох, тэтгэврийн даатгалын нэрийн дансыг бүртгэх, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, өвлүүлэх, шимтгэлийн өр, хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, нийгмийн даатгалын сангийн хэтийн тооцоолол хийх, сангийн эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороодыг ажиллуулах, ажил олгогч, даатгуулагчийн эрх үүрэг, Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо, нийгмийн даатгалын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг зохицуулалтыг тусгав.</li> <li>- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах, тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлэх, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэвэр бодоход баримтлах ХХТАО-ын дунжийг 5 жилээр тооцох, олон жил шимтгэл төлсөн даатгуулагчийг урамшуулах, тэтгэврийн нас, тэтгэвэр бодох аргачлал, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар шилжих зэрэг асуудлыг тусгасан болно.</li> </ul>	90
	2.	Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох эрх зүйн	-	Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хууль,	Иргэд суурь тэтгэвэр авах эрх зүйн орчин бүрдсэн байна.	Тэтгэврийн тогтолцоог шинэчилж олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх бодлогын хүрээнд эхний давхарга нь нийгмийн халамжийн тэтгэвэр байхаар нийгмийн халамжийн тэтгэврийн хуулиар зохицуулж	90

		орчинг бүрдүүлнэ.		эрх зүйн орчин бүрдээгүй байна.		улсын төсвөөс олгохоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд тусгасан болно.	
	3.	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	-	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна.	Иргэд хувийн тэтгэврийн даатгалд даатгуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.	Тэтгэврийн тогтолцоог шинэчилж олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх бодлогын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар Нийгмийн даатгалын багц хуулийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга бэлтгэх Ажлын хэсгийг холбогдох төрийн болон олон нийтийн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан байгуулж, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Улсын Их Хуралд өргөн барьсан болно.	90
2.5.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.	1.	Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчны хүрээнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	-	Хууль эрх, зүйн орчин бүрдээгүй байна.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад оруулах, санхүүгийн хэрэгслийг тодорхойлох, тэтгэврийн даатгалын нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг мөнгөжүүлэн хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлэх асуудлыг тусгасан.	90
2.5.4. Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	1.	Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ. нэвтрүүлнэ.	-	Ажилгүйдлийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн уялдаа холбоо хангалттай биш.	Хууль эрх зүйн шинэчлэл хийгдэж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны эрх зүйн үндэс бүрэн бүрдсэн байна.	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлд тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгох, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлыг тусгасан. Хуулийн төсөлд бөөрний дутагдал, эрхтэн шилжүүлэх, эрхтэний донор болсон даатгуулагчид олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, ихэр хүүхэд төрүүлсэн эхийн амаржсаны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг ОУХБ-ын минимум стандартад нийцүүлэх, даатгуулагчийг ажилгүй болохоос урьдчилан сэргийлэх, ажлын байранд нь тогтвор, суурьшилтай, урт хугацаанд ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчид 5 жилд 1 удаа 10 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлж байсныг сангийн чадавхид үндэслэн 3 жилд нэг удаа 15 хувиар хөнгөлөлт үзүүлэхээр тусгав. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлд эдгээр асуудлыг тусгасан болно.	90
2.5.5 Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн	2.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн	Улсын төсөв	Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 550.0 мян	Инфляцийн түвшинтэй уялдуулан тэтгэврийн	Засгийн газраас нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан Нийгмийн даатгалын сангийн 2023 оны	100



<p>бүтээмжтэй уялдуулан шаттайгаар нэмэгдүүлнэ.</p>	<p>үе</p>	<p>хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.</p>	<p>-</p>	<p>төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 440.0 мян.төгрөг</p>	<p>хэмжээг нэмэгдсэн байна.</p>	<p>төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Инфляцийн түвшинтэй уялдуулан бүрэн тэтгэврийн хэмжээг 550,0 мян.төг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээг 440.0 мянган төгрөг болж бусад тэтгэврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэхэд нийт 485.3 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн нэмэгдэлд жилд 388.7 тэрбум төгрөг, 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлэхэд 194.4 тэрбум төгрөг нэмж зарцуулахаар байна.</p>	<p></p>
	<p>3.</p>	<p>Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтооно.</p>	<p>-</p>	<p>Засгийн газрын тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг тогтоосон.</p>	<p>Тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоож, тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэн, тэтгэврийн зөрүү ойртсон байна.</p>	<p>Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлэн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан. 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчилснээр 164.6 мянган хүний тэтгэвэр өөрчлөгдөн, нэг хүний тэтгэвэр дунджаар 188.9 мян.төгрөгөөр нэмэгдэж жилд 400.3 тэрбум төгрөг, 2023 оны 7 лугаар сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлэхэд 200.2 тэрбум төгрөг шаардагдана.</p>	<p>100</p>
<p>2.5.6 "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй болгоно.</p>	<p>2.</p>	<p>Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим хэлбэрээр хүргэнэ.</p>	<p>400.0 Гадаад ын зээл тусламж</p>	<p>Нийгмийн даатгалын үйлчилгээний 25 хувь цахимжсан.</p>	<p>Нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулсан байна.</p>	<p>"Цахим Монгол" арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгууллагуудад нийгмийн даатгалын үйлчилгээг цаг хугацаа, орон зайн хамааралгүйгээр 24/7 цагийн горимоор цахим хэлбэрээр түргэн шуурхай хүргэх ажлыг өргөжүүлэн ажиллалаа. Тухайлбал: 1. Иргэд даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актаа E-Mongolia порталаас цахимаар авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор батлагдсан маягтын дагуу нийт 22 төрлийн мэдээлэл агуулсан сервисийг боловсруулан И-Монгол академи УТҮГ-т ашиглах боломжийг бүрдүүлэв. Ингэснээр нийт 103.0 мянган иргэн энэхүү шийдвэрийг цахимаар авах боломж бүрдсэн. 2. Даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ, мөн сайн дураар даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргах хугацаа дуусахаас 8 хоногийн өмнө сануулах мэдэгдлийг тухайн даатгуулагчийн гар утасны дугаар руу мессежээр илгээх "Message" системийг боловсруулан нэвтрүүллээ. Даатгуулагч уг мэдэгдлийн дагуу хүсэлтээ E-Mongolia портал, "Даатгуулагчдад зориулсан вэб" системийг ашиглан цахимаар илгээх боломжтой бөгөөд эхний хагас жилийн байдлаар нийтдээ 6.4 мянган даатгуулагчид сануулах мессежийг илгээсэн байна. Мөн дараах сервисийг боловсруулан нэвтрүүллээ. Үүнд: 1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас "Өрхийн нэгдсэн мэдээллийн сан" үүсгэхтэй холбогдуулан даатгуулагчийн цалин, тэтгэврийн мэдээллийн сервисийг боловсруулан ХУР системд ашиглах боломжийг бүрдүүлэв. 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхийг E-Mongolia порталд харуулах зорилгоор ЭХМК-ын хурлаар тогтоолт, сунгалт хийлгэсэн иргэний мэдээлэл дамжуулах сервисийг боловсруулан И-Монгол академи УТҮГ-т ашиглах боломжийг бүрдүүлэв. 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санг үүсгэхтэй холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагын даатгуулагчдын тоо болон</p>	<p>90</p>

					<p>хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон мэдээллийг авах сервисийг боловсруулан ХУР системд ашиглах боломжийг бүрдүүлэв.</p> <p>Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах ажлыг өргөжүүлснээр 2023 оны эхний хагас жилийн байдлаар дараах үр дүнгүүд гарсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- "Нийгмийн даатгал" аппликейшнийг нийтдээ 260.0 мянган иргэн идэвхтэй ашиглаж 22 төрлийн үйлчилгээ, мэдээллийг цахимаар авсан байна.</li> <li>- "Даатгуулагчдад зориулсан вэб" системд 482.2 мянга орчим удаагийн хандалт хийж 29 төрлийн үйлчилгээг цахимаар авсан байна.</li> <li>- 24.4 мянган даатгуулагч сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, хугацаа сунгах, төлбөрөө төлөх үйлчилгээнд онлайнаар хамрагдсан байна.</li> <li>- Давхардсан тоогоор 47.5 мянган ажил олгогч, 1.2 сая даатгуулагч цахимаар хандан QR кодтой шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо авсан байна.</li> <li>- Төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаас 74.2 мянган иргэд даатгуулагч, ажил олгогч дөрвөн төрлийн лавлагаа, тодорхойлолтоо хэвлэн авсан байна.</li> <li>- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолтын бодит байдлыг шалгах вэб системээр Элчин сайдын яамдууд, банк, санхүүгийн байгууллагаас 2.2 мянган ажил олгогч, 15.7 мянган даатгуулагчийн шимтгэл төлөлтийн QR кодтой тодорхойлолтыг шалгасан байна.</li> <li>- Идэвхтэй шимтгэл төлж буй 55.5 мянган ажил олгогч сар бүрийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаа 100% цахимаар, үүнээс 23% нь тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн байна.</li> <li>- "Шимтгэлийн цахим систем"-ээр 2.0 мянган ажил олгогчийн 11.9 мянган тушаалын мэдээллийг цахимаар хүлээн авсан байна.</li> <li>- 1,009 эрүүл мэндийн байгууллагаас 110.0 гаруй мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авсан байна.</li> <li>- Нийт 65.9 мянган даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 27.0 орчим мянган даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтийг цахимаар хүлээн авсан байна.</li> <li>- "Шимтгэлийн цахим систем"-ээр 8.0 мянган ажил олгогч 63.5 мянган даатгуулагчийн ХЧТА-ны тэтгэмжийг илгээсэн байна.</li> <li>- Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болсон 330 даатгуулагч ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээсэн байна. Түүнчлэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу 2022 оны 4 дүгээр улирлын 16 нэр төрлийн нээлттэй мэдээллийг тус бүр дөрвөн форматаар хувирган ЗГХЭГ-ын <a href="http://www.opendata.gov.mn">www.opendata.gov.mn</a> болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> веб сайтуудад тус тус байршуулсан.</li> </ul>	
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ					92.5	